

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/281/НА/-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН МЭРГЭЖИЛ СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл.....
 - 4.2 Материаллаг байдал.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/161
танай _____ -ны № _____ -г

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ Д.БОЛОРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 4 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 95,4 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг шалгахад санхүүжилтийг үр дүнд суурилсан гүйцэтгэлтэй холбогдуулан тайлант оны төсвийг Улсын төсвөөс 374,022.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж өгсөн. Тайлант

019020300

онд Нэгдсэн үндэсний байгууллагаас 64,808.8 мянган төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан зэргээс шалтгаалан төсвийн гүйцэтгэл өссөн байна.

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитыг хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тус бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	161,302,935.09	251,330,680.30
60	БАРАА МАТЕРИАЛ	161,302,935.09	251,330,680.30
61	Түүхий эд материал	761,146.59	4,064,391.80
63	Эм боох материал	761,146.59	4,064,391.80
66	Хангамжийн материал	130,441,788.50	212,836,288.50
67	Бичиг хэргийн материал	4,020,507.00	9,280,727.00
68	Аж ахуйн материал	60,436,657.00	68,227,577.00
69	Сэлбэг хэрэгсэл	267,939.50	1,659,189.50
71	Барилгын засварын материал	56,391,605.00	71,628,005.00
72	Хүнсний материал	8,720,080.00	39,544,490.00
73	Бусад хангамжийн материал	605,000.00	22,496,300.00
75	Мал, амьтад	30,100,000.00	34,430,000.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,022,360,790.99	2,072,318,001.64
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,022,360,790.99	2,072,318,001.64
108	Биет хөрөнгө	1,398,074,681.71	1,436,464,392.36
109	Барилга, байгууламж	1,445,326,579.00	1,459,172,979.00
110	Хуримтлагдсан элэгдэл	(208,227,783.68)	(313,640,469.66)
111	Авто тээврийн хэрэгсэл	133,168,083.30	133,168,083.30
112	Хуримтлагдсан элэгдэл	(133,168,083.30)	(133,168,083.30)
113	Машин, тоног төхөөрөмж	179,598,695.83	191,247,360.35
114	Хуримтлагдсан элэгдэл	(119,683,648.06)	(49,027,806.77)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	170,597,616.66	195,700,126.43
116	Хуримтлагдсан элэгдэл	(96,217,082.04)	(74,909,550.99)
125	Номын фонд	26,680,304.00	27,921,754.00
126	Биет бус хөрөнгө	624,286,109.28	635,853,609.28
127	Програм хангамж	16,525,000.00	11,567,500.00
128	Хасагдуулга	(16,525,000.00)	
129	Бусад биет бус хөрөнгө	624,286,109.28	624,286,109.28
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,183,663,726.08	2,323,648,681.94
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	11,924,268.00	29,368,676.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,924,268.00	29,368,676.00
164	Өглөг	11,924,268.00	29,368,676.00
170	Бусад өглөг	11,924,268.00	29,368,676.00
171	Байгууллагад төлөх өглөг	11,924,268.00	29,368,676.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,171,739,458.08	2,294,280,005.94
215	Засгийн газрын хувь оролцоо	2,171,739,458.08	2,294,280,005.94
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	1,198,901,961.28	1,198,901,961.28
217	Өмч: -Төрийн өмч	1,198,901,961.28	1,198,901,961.28
223	Хуримтлагдсан үр дүн	(531,837,430.00)	(409,296,882.14)
224	Өмнөх үеийн үр дүн	(531,837,430.00)	(531,837,430.00)
225	Тайлант үеийн үр дүн	-	122,540,547.86
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,504,674,926.80	1,504,674,926.80
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,183,663,726.08	2,323,648,681.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,196,241,204.00	1,638,247,110.43
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,817,700.00	89,405,610.43
77	Нийтлэг татварын бус орлого	11,860,900.00	86,402,610.43
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	11,860,900.00	86,402,610.43
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,000.00	13,083,800.00
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,510,900.00	8,510,000.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	64,808,810.43
99	Тусламжийн орлого	4,956,800.00	3,003,000.00
100	Хандив тусламж /дотоод/	4,956,800.00	3,003,000.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,179,423,504.00	1,548,841,500.00
112	Улсын төвлөрсөн төсвөөс	945,961,300.00	1,319,983,800.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	945,961,300.00	1,319,983,800.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,846,504.00	-
127	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,846,504.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	224,615,700.00	228,857,700.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	224,615,700.00	228,857,700.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,389,644,597.59	1,602,564,827.12
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,389,644,597.59	1,602,564,827.12
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,243,202,932.16	1,494,178,293.32
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	660,125,245.63	837,983,070.73
151	Цалин	454,555,787.97	496,289,861.24
152	Нэмэгдэл цалин	134,244,027.10	269,360,116.67
153	Унаа хоолны хөнгөлөлт	25,558,143.29	29,500,211.91
154	Урамшуулал	45,767,287.27	42,832,880.91
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,014,970.94	109,412,172.47
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	60,313,316.10	74,713,610.10
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	6,481,346.75	8,827,189.82
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,000,277.35	6,969,671.78
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,196,399.55	1,726,660.31
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	12,023,631.19	17,175,040.46
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,985,768.00	239,002,108.00
165	Гэрэл цахилгааны зардал	33,468,500.00	38,947,075.86
166	Түлш, халаалтын зардал	145,092,268.00	191,887,532.14
167	Цэвэр, бохир усны зардал	7,425,000.00	8,167,500.00
170	Хангамж, бараа материалын зардал	29,821,875.00	16,482,530.00
171	Бичиг хэргийн материал	4,884,831.00	1,184,050.00
172	Тээвэр, шатахууны зардал	8,684,304.00	7,918,900.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	5,301,070.00	4,121,700.00

174	Ном, хэвлэлийн зардал	167,000.00	370,360.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,312,290.00	1,217,960.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	9,472,380.00	1,669,560.00
181	Нормативт зардал	39,463,433.41	53,377,194.79
182	Эм	257,953.41	2,618,564.79
183	Хоол	35,221,180.00	50,758,630.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,984,300.00	-
185	Эд хогшил, урсгал засварын зардал	7,034,480.00	9,804,550.00
188	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,215,000.00	2,504,550.00
189	Урсгал засвар	5,819,480.00	7,300,000.00
190	Томилолт, зочны зардал	3,027,000.00	5,372,000.00
192	Дотоод томилолтын зардал	3,027,000.00	5,372,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,932,798.00	4,778,375.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	870,500.00	2,649,100.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,419,200.00	1,225,200.00
197	Даатгалын үйлчилгээний төлбөр	347,850.00	234,900.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	200,248.00	-
199	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	70,100.00
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	387,000.00	460,700.00
201	Газрын төлбөр	217,200.00	-
202	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	347,800.00	138,375.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	227,797,361.18	217,966,292.33
210	Бараа үйлчилгээний бусад зардал	45,500,000.00	32,540,000.00
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	32,856,020.00	53,449,378.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,441,341.18	131,976,914.33
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,441,665.43	108,386,533.80
228	Бусад урсгал шилжүүлэг	40,881,300.00	43,368,807.50
231	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	138,704.25
234	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,433,100.00	-
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,448,200.00	38,802,682.00
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	4,427,421.25
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	105,560,365.43	65,017,726.30
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,560,365.43	65,017,726.30
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(193,403,393.59)	35,682,283.31
269	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	40,800,000.00	88,133,724.55
271	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	40,800,000.00	88,133,724.55
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	1,275,460.00
277	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,275,460.00
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	40,800,000.00	86,858,264.55
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(152,603,393.59)	122,540,547.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,179,773,504.00	1,561,925,300.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	350,000.00	13,083,800.00
78	Нийтлэг татварын бус орлого	350,000.00	13,083,800.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	350,000.00	13,083,800.00
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	350,000.00	13,083,800.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,179,423,504.00	1,548,841,500.00
111	Улсын төвлөрсөн төсвөөс	945,961,300.00	1,319,983,800.00
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	945,961,300.00	1,319,983,800.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,846,504.00	-
126	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	8,846,504.00	-
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	224,615,700.00	228,857,700.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	224,615,700.00	228,857,700.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,176,191,604.00	1,561,925,300.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,176,191,604.00	1,561,925,300.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,029,749,938.57	1,453,538,766.20
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	660,125,245.63	838,139,478.87
151	Үндсэн цалин	454,449,055.43	496,272,273.56
152	Нэмэгдэл	134,350,759.64	269,534,112.49
153	Унаа хоолны хөнгөлөлт	25,558,143.29	29,500,211.91
154	Үр дүнгийн урамшуулал	45,767,287.27	42,832,880.91
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	85,014,970.94	109,255,764.33
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	60,313,316.10	74,370,500.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	6,481,346.75	8,749,500.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,000,277.35	6,999,600.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,196,399.55	1,749,900.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	12,023,631.19	17,386,264.33
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	174,061,500.00	221,557,700.00
165	Гэрэл цахилгааны зардал	33,468,500.00	40,164,200.00
166	Түлш, халаалтын зардал	133,168,000.00	173,226,000.00
167	Цэвэр, бохир усны зардал	7,425,000.00	8,167,500.00
170	Хангамж, бараа материалын зардал	22,194,284.00	28,100,710.00
171	Бичиг хэрэг	3,252,400.00	4,713,400.00
172	Тээвэр, шатахуун	8,496,804.00	7,918,900.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,301,070.00	4,121,700.00
174	Ном, хэвлэл	87,000.00	1,611,810.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,617,300.00	3,934,700.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,439,710.00	5,800,200.00
181	Нормативт зардал	39,549,010.00	100,601,340.00
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	856,600.00	3,391,100.00
183	Хоол, хүнс	33,921,210.00	79,383,040.00

184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,771,200.00	17,827,200.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	9,825,300.00	14,550,530.00
188	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	4,310,000.00	7,250,530.00
189	Урсгал засвар	5,515,300.00	7,300,000.00
190	Томилолт, зочны зардал	3,027,000.00	5,372,000.00
192	Дотоод албан томилолт	3,027,000.00	5,372,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,397,228.00	5,282,175.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	861,000.00	3,152,900.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,419,200.00	1,225,200.00
197	Даатгалын үйлчилгээ	347,850.00	234,900.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	209,748.00	-
199	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	70,100.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	851,430.00	460,700.00
201	Газрын төлбөр	217,200.00	-
202	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	347,800.00	138,375.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	30,555,400.00	130,679,068.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	30,555,400.00	130,679,068.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,441,665.43	108,386,533.80
225	Бусад урсгал шилжүүлэг	40,881,300.00	43,368,807.50
231	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,433,100.00	-
232	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,448,200.00	38,802,682.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	4,566,125.50
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	105,560,365.43	65,017,726.30
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,560,365.43	65,017,726.30
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,581,900.00	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,581,900.00	-
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,581,900.00	-
263	Дотоод эх үүсвэрээр	3,581,900.00	-
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,581,900.00	-
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,581,900.00)	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	574,615,852.00	435,473,427.13	(272,562,563.97)	737,526,715.17
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	574,615,852.00	435,473,427.13	(272,562,563.97)	737,526,715.17
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	624,286,109.28		(27,912,543.00)	596,373,566.27
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	(531,837,430.00)	2,171,739,458.08
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	(531,837,430.00)	2,171,739,458.08
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	(531,837,430.00)	2,171,739,458.08
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	122,540,547.86	122,540,547.86
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,198,901,961.28	1,504,674,926.80	(409,296,882.13)	2,294,280,005.94

5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,319,983,900.00	1,259,815,973.70	60,167,926.30	95.4
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,319,983,900.00	1,259,815,973.70	60,167,926.30	95.4
4	Бараа, үйлчилгээний зардал	1,280,226,200.00	1,220,181,066.20	60,045,133.80	95.3
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	874,947,300.00	838,139,478.87	36,807,821.13	95.8
6	Үндсэн цалин	487,328,400.00	496,272,273.56	(8,943,873.56)	101.8
7	Нэмэгдэл	276,725,100.00	269,534,112.49	7,190,987.51	97.4
8	Унаа, болон бусад нөхөн олговор	33,888,100.00	29,500,211.91	4,387,888.09	87.1
9	Урамшуулал	77,005,700.00	42,832,880.91	34,172,819.09	55.6
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,368,400.00	109,255,764.33	112,635.67	99.9
12	Тэтгэврийн даатгал	74,370,500.00	74,370,500.00	0.00	100.0
13	Тэтгэмжийн даатгал	8,749,500.00	8,749,500.00	-	100.0
14	ҮОМШӨ ний даатгал	6,999,600.00	6,999,600.00	-	100.0
15	Ажилгүйдлийн даатгал	1,749,900.00	1,749,900.00	-	100.0
16	Эрүүл мэндийн даатгал	17,498,900.00	17,386,264.33	112,635.67	99.4
22	Хангамж, бараа материалын зардал	29,055,900.00	28,100,710.00	955,190.00	96.7
23	Бичиг хэрэг	4,893,400.00	4,713,400.00	180,000.00	96.3
24	Тээвэр (шатахуун)	7,990,900.00	7,918,900.00	72,000.00	99.1
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,140,800.00	4,121,700.00	19,100.00	99.5
26	Ном, хэвлэл	2,292,900.00	1,611,810.00	681,090.00	70.3

27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,937,700.00	3,934,700.00	3,000.00	99.9
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	5,800,200.00	5,800,200.00	-	100.0
30	Нормативт зардал	115,218,200.00	96,101,340.00	19,116,860.00	83.4
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	3,391,100.00	3,391,100.00	-	100.0
32	Хоол, хүнс	98,499,800.00	79,383,040.00	19,116,760.00	80.6
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	13,327,300.00	13,327,200.00	100.00	100.0
34	Эд хогшил худалдан авах	7,276,000.00	7,250,530.00	25,470.00	99.6
37	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	7,276,000.00	7,250,530.00	25,470.00	99.6
39	Томилолт, зочны зардал	6,314,400.00	5,372,000.00	942,400.00	85.1
41	Дотоод албан томилолт	6,314,400.00	5,372,000.00	942,400.00	85.1
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	7,345,900.00	5,282,175.00	2,063,725.00	71.9
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,953,000.00	3,152,900.00	1,800,100.00	63.7
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,225,200.00	1,225,200.00	-	100.0
46	Даатгалын үйлчилгээ	234,900.00	234,900.00	-	100.0
47	Тээврийн хэрэгслийн татвар	125,100.00	-	125,100.00	-
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	70,100.00	70,100.00	-	100.0
49	Мэдээллийн технологийн зардал	460,700.00	460,700.00	-	100.0
50	Газрын төлбөр	106,400.00	-	106,400.00	-
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	170,500.00	138,375.00	32,125.00	81.2
53	Бараа үйлчилгээний бусад зардал	130,700,100.00	130,679,068.00	21,032.00	100.0
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,700,100.00	130,679,068.00	21,032.00	100.0
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,757,700.00	39,634,907.50	122,792.50	99.7
70	Бусад урсгал шилжүүлэг	39,757,700.00	39,634,907.50	122,792.50	99.7
77	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	38,802,700.00	38,802,682.00	18.00	100.0
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	955,000.00	832,225.50	122,774.50	87.1
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭЛ	1,319,983,800.00	1,320,248,600.00	(264,800.00)	100.0
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,319,983,800.00	1,319,983,800.00	-	100.0
99	Улсын төсвөөс санхүүжих	1,319,983,800.00	1,319,983,800.00	-	100.0
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	264,800.00	(264,800.00)	-
111	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	264,800.00	(264,800.00)	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	46.00	48.00	(2.00)	104.3
134	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.0
135	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00	-	100.0
136	Үйлчлэх ажилтан	15.00	17.00	(2.00)	113.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь Мал аж ахуй, мал эмнэлэг, уул уурхай, нөхөн сэргээлтийн чиглэлээр болон шаталсан сургалттай мэргэжлийн анхан, дунд шатны сургалт эрхлэн үйл ажиллагаа явуулдаг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 46 батлагдсан орон тоотой боловч 2023 онд 48 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд: удирдах ажилтан 1, гүйцэтгэх 23, үйлчилгээний 24, үүнээс гэрээтээр 2 ажилтан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 11 сард Төв аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтад хамрагдаж 93%-тай дүгнэгдсэн. Мөн 2023 онд Төв аймгийн санхүү хяналт, аудитын албанаас 2021-2022 оны санхүүгийн тайланд хяналт шалгалт хийж шилэн дансны мэдээлэл, нягтлан бодох бүртгэл, анхан шатны бүртгэл хөтлөлт шаардлагын түвшинд гэж дүгнэсэн байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл/мөнгөн* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Заамар сумын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139,984.9 мянган төгрөгөөр буюу 6,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	161,302.9	251,330.6	90,027.7
Үндсэн хөрөнгө	2,022,360.8	2,072,318.0	49,957.2
Нийт хөрөнгө	2,183,663.7	2,323,648.6	139,984.9
Өр төлбөр	11,924.3	29,368.7	17,444.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,171,739.4	2,294,280.0	122,540.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,183,663.7	2,323,648.7	139,985.0

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материалын дансны үлдэгдэл 90,027.7 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь: а/Улсын төсвийн хөрөнгөөр 209,254.3 мянган төгрөгийн, өөрийн хөрөнгөөр 1,280.0 мянган төгрөгийн хангамжийн бараа материалыг худалдан авсан. б/Хандиваар 1,290.0 мянган төгрөгийн сэлбэг, 920.0 мянган төгрөгийн хүнсний бараа материал авсан.

в/Байгууллагын өөрийн үйл ажиллагаанд 127,246.6 мянган төгрөгийн хангамжийн бараа материалыг зарцуулсан .

г/Тайлант онд төсөвт байгууллагад шилжүүлсэн мал амьтан 1,500.0 мянган төгрөг зэргээс шалтгаалан бараа материалын үлдэгдэлд өссөн өөрчлөлт орсон байна.

Үндсэн хөрөнгө данс үлдэгдэл 49,957.9 мянган төгрөгөөр өссөн нь

а/ Улсын төсвөөр 59,114.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном авсан.

б/ Хандиваар барилга байгууламжийн дээврийн засварт 13,846.4 мянган төгрөг, Машин тоног төхөөрөмж 37,073.0 мянган төгрөг нийт 53,289.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө авсан байна.

в/ Тайлант онд Төв аймгийн орон нутгийн өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 05/324 тоот албан тоотын дагуу Дахин үнэлгээний нэмэгдлээр 70,808.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дансанд бүртгэсэн. Үүнд: программ хангамж 11,567.5 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 17,491.3 мянган төгрөг, тоног төхөөрөмж 41,747.3 мянган төгрөг тус тус байна.

г/Тайлант онд тус Заамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаас гаргасан 04 тоот тогтоолоор тус байгууллагын 48 нэр төрлийн 35,176.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хассан байна.

д/ Тайлант онд 131,976.9 мянган төгрөгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулсан.

Дээрх ажил гүйлгээнээс шалтгаалан үндсэн хөрөнгө 49,957.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өглөг дансны үлдэгдэл 17,444.4 мянган төгрөгөөр өссөн нь Ану сервис ХХК-нд халаалтын зардлын өр үүссэнтэй холбоотой байна. Энэ нь Тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,319,983.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 228,857.7 мянган төгрөг, нийт 1,557,341.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төслийг 1,557,341.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,561,925.3 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,319,983.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 228,857.7 мянган төгрөгийг, үйл ажиллагааны орлогоос 13,083.8 мянган төгрөгийг нийт 1,561,925.3 мянган төгрөгийн төсөв бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,259,815.9 мянган төгрөг буюу 95,4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал, дотуур байрны хүүхдийн хоолны зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал зэргийг нийт 60,167.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71804	Тусгай мэргэжлийн боловсрол	1,548,841.6	1,488,673.6	60,168	95,4
80101	Үндсэн үйл ажиллагаа	1,181,726.4	1,140,798.0	40,928.4	95,3
80802	Дотуур байрны хүүхдийн хоол	98,499.8	79,383,0	19,116.7	80,6
80806	Бусад үрсгал шилжүүлэг	39,757.7	39,634.9	122,8	99,7
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	228,857.7	228,857.7		100,0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилт данс байхгүй

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллага нь 1 хөтөлбөр 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71411-80101	2023,12,31	Үндсэн үйл ажиллагаа	95,3%	1,181,726.4	1,140,798.0
2	71411-80804-06	2023,12,31	Дотуур байрны хүүхдийн хоол	80.6	98,499.8	79,383.0
3	71411-80802	2023,12,31	Урсгал шилжүүлэг	99,7	39,757.7	39,634.9
4	71411-80111	2023,12,31	Төрийн өмчийн барилга тогтмол зардал	100,0	228,857.7	228,857.7

Хэрэгжилт хангалтгүй биелэгдсэн 1 арга хэмжээ байна. Энэ нь Дотуур байрны хүүхдийн хоол арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь цахим болон танхим хосолсон сургалтаас хүүхдийн тоо хэлбэлзэлтэй байснаас шалтгаалсан гэж үзжээ.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Заамар сумын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь 2023 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Аймгийн ИТХ аар батлуулан ажилласан ба худалдан авах ажиллагааны зохих хууль журмаар хийгдсэн гэж үзлээ. .

Мөн Тендер зарласан боловч аж ахуйн нэгж байгууллага оролцоогүй тул шууд худалдан авалтыг дараах компаниудаас хийсэн байна. Үүнд:

- Авдрантын өгөөж ХХК-аас 11,160.4 мянган төгрөгийн аж ахуйн материал,
- Галт бадрах ХХК-аас 18,963.9 мянган төгрөгийн хангамжийн материал,
- Солюшн ойл ХХК-аас 4,816.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл,
- Эрхэм ундраа ХХК-аас 48,998.9 мянган төгрөгийн хоол хүнс, бичиг хэргийн материал,
- Хишиг дөлгөөн хэм ХХК, НИК ХХК, Олимпус ХХК, Оргил заамар ХХК, Сая төмөрт ХХК зэрэг компаниудаас 206,369.9 мянган төгрөгийн шатахуун, хангамжийн болон бусад сургалтын материал авсан.

Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгдээгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дансны ангилал болон анхан шатны бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь төрийн аудитын менежер О.Амаржаргал, дарга тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 02 дүгээр сарын 16-ны өдрийн 1/13 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,075,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 21,500.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17,200.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 36,808.0 мянган төгрөгөөр
- Хангамжийн бараа материал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 955.2 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 19,117.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 158 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 1 мэдээлэл хоцроож байршуулсан байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллахыг анхааруулав.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болсон төсвийн гүйцэтгэлийн тайланд хийгдсэн Завсрын аудитын явцад зардлын данстай холбоотой 1,491,8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин 1 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	212,4	1	212,4	100,0
Албан шаардлага	3	146,677.6	3	146,677.6	100,0

Зөвлөмж	3	17,857.6	3	17,857.6	100.0
Нийт дүн	8	164,947,6	2	164,947,6	100.0

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Урьд оны аудитын төлбөрийг барагдуулж, зөрчлийг арилгасан гэж үзсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Заамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 73,418.1 мянган төгрөгийн 2 алдаа, 2 зөрчил илэрснээс аудитын явцад 57,176.3 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 15,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,241.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгсөн. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

Шатахуун зарцуулалтын тайланг шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу, автомашин хэрэглэгчийн гарын үсэг дутуу 250.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг зардалд тооцож бичилт хийсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсний дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн болно.

2. Хөрөнгийн данстай холбоотой

Тухайн байгууллага 56,926.3 мянган төгрөгийн Мал болон бусад хангамжийн бараа материалыг жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нягтлан бодогч өвчтэй гэсэн шалтгаанаар тоолоогүй байсныг дараа жилийн 1 сард нөхөж тоолсон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2.1.1-д “Жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө хөрөнгийн тооллогыг заавал хийнэ” гэсэн заалт, Санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсний дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн болно.

5.1 Төлбөрийн акт:

1. Зардлын данстай холбоотой

Хүнсний бараа материал, хангамжийн бусад бараа материалыг 2021 оноос эхлэн он дамжин үлдэгдлээр нөөцлөгдсөн 15,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсөв зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр материал бэлтгэж нөөцлөхгүй байх” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4-т “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр, эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. Зардлын данстай холбоотой

2023 оны 05 дугаар сард дотуур байрны хүүхдийн 1,241.8 мянган төгрөгийн хоолыг орц нормын дагуу бодоогүй зөрчил илэрлээ. Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, эрүүл мэндийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн А/166, А/559, 222 дугаар хамтарсан тушаалын хоолны материалын норм нормативыг баримтлан ажиллаагүй, Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6-д “Эрх бүхий этгээдээс тогтоосон норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн хоолны орц нормыг зохих хууль тогтоомжийн дагуу бүрэн гүйцэтгэж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны зарцуулалтын тайланд хэрэглэгчийн гарын үсэг дутуу	1	250.0					1	250.0				
Тооллогыг хугацаанд нь хийгээгүй /мал, бусад хангамжийн бараа материал/	1	56,926.3					1	56,926.3				
Дүн	2	57,176,3					1	57,176,3				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хэрэгцээнээс илүү Хүнс, хангамжийн бараа материалыг удаан хугацаагаар нөөцөлсөн	1	15,000.0	1	15,000.0								
Дотуур байрны хүүхдийн орц нормыг батлагдсан нормыг баримтлаагүй	1	1,241.8			1	1,241.8						
Дүн	2	16,241.8	1	15,000.0	1	1,241.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд байршуулах 159 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд байршуулж мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	1						1	
Дүн	1						1	
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn